

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ДАРВИ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/75/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 70432545 цахим хаяг: Doljinjav.b@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ДАРВИ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Л.МӨНХЖАРГАЛ ТАНАА

2021.03.10 № 2/159
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарви сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дарви сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод, хариуцлагатай байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан, төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, зардлыг бүлэг хооронд болон бүлэг дотор гүйлгэн зарцуулснаар санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох эрхзүйн актуудтай нийцэхгүй, аудитын “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

021020687

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.Б. ОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,869,100.00	58,153,100.00
33	АВЛАГА	-	10,585,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	10,585,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,869,100.00	47,568,100.00
354	Хангамжийн материал	10,869,100.00	12,568,100.00
35410	Бичиг хэргийн материал	1,999,000.00	2,273,500.00
35420	Аж ахуйн материал	-	164,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,870,100.00	10,130,600.00
35600	Мал амьтад	35,000,000.00	35,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,265,058,216.00	1,410,117,315.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,265,058,216.00	1,410,117,315.94
392	Биет хөрөнгө	1,234,308,216.00	1,377,517,315.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,371,801,147.00	1,545,698,943.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(242,773,081.00)	(333,888,613.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	227,731,515.00	138,931,950.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(189,081,565.00)	(111,371,990.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	181,114,695.00	188,490,998.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,575,595.00)	(143,793,838.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,607,827.00	139,170,327.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,516,727.00)	(45,720,460.60)
393	Биет бус хөрөнгө	30,750,000.00	32,599,999.96
39301	Програм хангамж	1,445,000.00	3,945,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(695,000.00)	(1,345,000.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,310,927,316.00	1,468,270,415.94
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,310,927,316.00	1,468,270,415.94
51	Засгийн газрын хувь оролцоо	1,310,927,316.00	1,468,270,415.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	662,858,897.00	662,858,897.00
51101	Өмч: - төрийн	662,858,897.00	662,858,897.00
512	Хуримтлагдсан үр дүн	329,386,713.00	486,729,812.94
51210	Өмнөх үеийн үр дүн	329,386,713.00	329,386,713.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	157,343,099.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	318,681,706.00	318,681,706.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,310,927,316.00	1,468,270,415.94

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	781,758,919.00	702,723,972.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	376,980,822.00	278,576,759.30
120	Нийтлэг татварын бус орлого	376,980,822.00	278,576,759.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,070,000.00	278,576,759.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,320,000.00	1,320,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	750,000.00	277,256,759.30
120009	Бусад орлого	374,910,822.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	404,778,097.00	424,147,213.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,194,197.00	59,069,613.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,798,197.00	36,152,128.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,462,415.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	396,000.00	17,455,070.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	333,583,900.00	365,077,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	303,810,800.00	353,477,600.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	29,773,100.00	11,600,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	437,240,298.00	545,380,872.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,240,298.00	545,380,872.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435,860,904.00	527,674,506.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,726,217.00	241,925,377.00
210101	Үндсэн цалин	169,523,317.00	188,457,031.00
210102	Нэмэгдэл	35,202,900.00	53,468,346.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,830,777.00	30,075,867.00
210201	Тэтгэврийн даатгал	17,641,729.00	20,520,398.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,047,262.00	2,399,878.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,637,810.00	1,919,903.09
210204	Ажилгүйдлийн даатгал	409,452.00	475,971.53
210205	Эрүүл мэндийн даатгал	4,094,524.00	4,759,715.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,573,146.00	28,435,447.50
210301	Гэрэл, цахилгаан	1,833,546.00	2,842,365.00
210302	Түлш, халаалт	9,739,600.00	25,593,082.50
2104	Хангамж, бараа материалын зардал	24,793,700.00	32,058,805.50
210401	Бичиг хэрэг	2,983,000.00	3,122,942.00
210402	Тээвэр, шатахуун	16,866,800.00	19,156,347.50

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,443,900.00	2,228,717.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	7,550,799.00
2105	Нормативт зардал	402,000.00	71,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	71,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,342,700.00	709,930.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	114,550.00
210604	Урсгал засвар	8,142,700.00	595,380.00
2107	Томилолт, зочны зардал	10,259,400.00	3,877,576.00
210701	Гадаад албан томилолт	-	607,100.00
210702	Дотоод албан томилолт	10,259,400.00	3,270,476.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,057,439.00	19,166,333.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,704,439.00	18,103,644.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	645,229.00
210803	Даатгалын үйлчилгээ	390,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	384,960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	260,000.00	2,500.00
210807	Газрын төлбөр	138,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,875,525.00	171,354,070.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,498,163.00	39,982,911.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,377,362.00	131,371,159.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,379,394.00	17,706,366.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	275,000.00	7,929,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	7,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275,000.00	479,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,104,394.00	9,713,866.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,104,394.00	9,713,866.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	62,900.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	62,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	344,518,621.00	157,343,099.94
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,777,242.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,777,242.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,777,242.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	341,741,379.00	157,343,099.94

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	405,702,097.00	425,467,213.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	924,000.00	1,320,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	924,000.00	1,320,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	924,000.00	1,320,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	924,000.00	1,320,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	404,778,097.00	424,147,213.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,194,197.00	59,069,613.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,798,197.00	36,152,128.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,462,415.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	396,000.00	17,455,070.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	333,583,900.00	365,077,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	303,810,800.00	353,477,600.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	29,773,100.00	11,600,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	362,694,036.00	425,467,213.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,694,036.00	425,467,213.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,314,642.00	396,895,147.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,608,044.00	239,567,886.00
210101	Үндсэн цалин	146,639,044.00	161,661,369.00
210102	Нэмэгдэл	32,766,100.00	44,754,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,202,900.00	33,151,717.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,171,820.00	29,998,485.00
210201	Тэтгэврийн даатгал	22,941,620.00	27,317,185.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,057,500.00	2,681,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,646,100.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	411,500.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	4,115,100.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,697,300.00	26,652,607.00
210301	Гэрэл, цахилгаан	3,939,200.00	3,629,107.00
210302	Түлш, халаалт	17,758,100.00	23,023,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,214,700.00	24,508,411.00
210401	Бичиг хэрэг	3,199,000.00	3,037,242.00
210402	Тээвэр, шатахуун	18,571,800.00	18,373,086.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,443,900.00	3,098,083.00
2105	Нормативт зардал	402,000.00	348,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	348,500.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,342,700.00	2,138,216.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	279,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	368,216.00
210604	Урсгал засвар	3,142,700.00	1,491,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,259,400.00	3,569,582.00
210702	Дотоод албан томилолт	10,259,400.00	3,569,582.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,741,100.00	21,193,314.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,778,100.00	19,492,584.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	943,370.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000.00	381,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	260,000.00	345,900.00
210807	Газрын төлбөр	138,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,877,578.00	48,918,146.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,877,578.00	48,918,146.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,379,394.00	28,572,066.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	275,000.00	8,210,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	7,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275,000.00	760,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,104,394.00	20,298,866.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,104,394.00	20,298,866.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	62,900.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	62,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	43,008,061.00	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	43,008,061.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,008,061.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	43,008,061.00	-
223001	Бусад хөрөнгө	43,008,061.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(43,008,061.00)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	(12,354,666.00)	969,185,937.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	(12,354,666.00)	969,185,937.00
Тайлант үеийн үр дүн	-	-	341,741,379.00	341,741,379.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	329,386,713.00	1,310,927,316.00
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	329,386,713.00	1,310,927,316.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	329,386,713.00	1,310,927,316.00
Тайлант үеийн үр дүн	-	-	157,343,099.94	157,343,099.94
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	486,729,812.94	1,468,270,415.94

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

ЭЗА	Зардлын нэр	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	365082400.00	366334700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365082400.00	366334700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357357400.00	358124400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240375000.00	239567886.00
210101	Үндсэн цалин	162754900.00	161661369.00
210102	Нэмэгдэл	43824800.00	44754800.00
210105	Гэрээт ажлын хөлс	33795300.00	33151717.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32450800.00	29806485.00
210201	Тэтгэврийн даатгал	22835700.00	27125185.00
210202	Тэтгэмжийн даатгал	2403800.00	2681300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1923000.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	480800.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4807500.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26756700.00	26652607.00
210301	Гэрэл, цахилгаан	3733200.00	3629107.00
210302	Түлш, халаалт	23023500.00	23023500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24357300.00	24508411.00
210401	Бичиг хэрэг	3199000.00	3037242.00
210402	Тээвэр, шатахуун	17753700.00	18373086.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,404,600.00	3,098,083.00
2105	Нормативт зардал	402,000.00	348,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	348,500.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,842,700.00	2,138,216.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	279,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	368,216.00
210604	Урсгал засвар	2,642,700.00	1,491,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,562,100.00	3,569,582.00
210702	Дотоод албан томилолт	4,562,100.00	3,569,582.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,893,300.00	17,755,468.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,181,300.00	16,054,738.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	943,370.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000.00	381,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	345,900.00
210807	Газрын төлбөр	147,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,717,500.00	13,777,245.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,717,500.00	13,777,245.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,725,000.00	8,210,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,725,000.00	8,210,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,450,000.00	7,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275,000.00	760,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	365,082,400.00	366,334,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	364,477,400.00	365,014,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	352,877,400.00	353,414,700.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11,600,000.00	11,600,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000.00	1,320,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	1,320,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	6	6

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,069,613.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,069,613.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,770,747.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,000.00
210201	Тэтгэврийн даатгал	192,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,437,846.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,437,846.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,140,901.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,140,901.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,298,866.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,298,866.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	20,298,866.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,069,613.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,069,613.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,152,128.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,462,415.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,455,070.00

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Дарви сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг байгууллагын дарга Л.Мөнхжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, орлогын бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 2021 оны 03 дугаар сарын 10-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Должинжав хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь Ковид -19 цар тахлаас хамааран хорио цээр тогтоосон, нягтлан бодогчийн ажлын хариуцлагаас хамааран хуулийн хугацаа хоцроож аудитад тайлангаа ирүүлсэн тул Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаа хоцорч тайланг аудитласан болно.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дарви сумын Засаг даргын Тамгын газар нь “Сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийг ханган, төрийн үйлчилгээг иргэдэд адил тэгш, түргэн шуурхай хүргэнэ” гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон ажилласан байна.

Сумын Засаг даргын Тамгын газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тодорхойлжээ. Үүнд:

1. Засгийн газрын бодлого шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах
2. Төрийн хууль тогтоомжийг сурталчлах хэрэгжүүлэх
3. Сумын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бүртгэл судалгааг хөтөлж, дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр хангах
4. Сумын хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ковид-19 вирусн нөхцөл байдлын улмаас Дарви сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хэрэгжүүлээгүй байна.

Дарви сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөө дунд гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1236651.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12366.5 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 555965.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5559.6 мянган төгрөгөөр тооцсон болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дарви сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 167057.0 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өсчээ. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	45,869.1	58,153.1	12,284.0
33	Авлага	0.0	10,585.0	10,585.0
35	Бараа материал	45,869.1	47,568.1	1,699.0
39	Үндсэн хөрөнгө	1,265,058.2	1,410,117.3	145,059.1
3	Нийт хөрөнгийн дүн	1,310,927.3	1,468,270.4	157,343.1
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,310,927.3	1,468,270.4	157,343.1
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,310,927.3	1,468,270.4	157,343.1

Авлага дансны үлдэгдэл дэх 10585.0 мянган төгрөг нь нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн хоорондын тооцооны авлага байна.

Бараа материалын данс оны эхэнд 45869.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 1699.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 47568.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болжээ. Хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Дүн
1	Оны эхний үлдэгдэл	45,869.1
2	Нэмэгдсэн	35,761.7
2.1	Худалдан авсан	34,935.2
2.2	Хандиваар	826.5
3	Хасагдсан	34,062.7
3.1	Худалдсан, зарцуулсан	34,062.7
4	Эцсийн үлдэгдэл	47,568.1

Бараа материалын дансны 47568.1 мянган төгрөгийн үлдэгдлийн 35000.0 мянган төгрөг нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй малжуулах төслийн мал амьтад бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө данс оны эхэнд 1863700.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 276430.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 93893.2 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, оны эцэст 2046237.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Оны эцэс дэх эргэлтийн бус хөрөнгийн цэвэр дүн нь хуримтлагдсан элэгдлийг хассанаар 1410117.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	1,863,700.1
2	Нэмэгдсэн	276,430.2
2.5	Бусад	276,430.2
3	Хасагдсан	93,893.2
302	Акталсан	93,893.2
4	Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,046,237.2
6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	598,641.9
801	Элэгдлийн зардал тайлант хугацааны	131,371.1

9	Дансны хасалт	(93,893.2)
10	Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	636,119.9
11	Үлдэгдэл өртөг	1,410,117.3

Тайланд онд нэмэгдсэн 276430.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна. Дэлгэрэнгүй харуулбал:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 8970.1 мянган төгрөгийн компьютер, техник тоног төхөөрөмж, программ хангамж,
- Дэлхийн байгаль хамгаалах сангаас 17196.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ТЭХ,
- Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 17805.0 мянган төгрөгөөр ахмадын өргөөний эд хогшил, 15000.0 мянган төгрөгийн малын зөөврийн хашаа,
- УТХО болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 77943.1 мянган төгрөгийн 4 худаг
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 139515.7 мянган төгрөгийн халуун усны ТЭХ, тоног төхөөрөмж

Биет бус хөрөнгөд 3945.0 мянган төгрөгийн өртөгтэй, 1345.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй программ хангамж, 1 байршилд 30000.0 мянган төгрөгийн үнэлгээтэй газар бүртгэлтэй байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл оны эхэнд 662858.8 мянган төгрөг байсан ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 79034.9 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар буурсан байна. Хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	781,758.9	702,724.0	(79,034.9)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,320.0	1,320.0	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	375660.8	277,256.8	- 98404.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,194.2	59,069.6	(12,124.6)
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	303,810.8	353,477.6	49,666.8
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	29,773.1	11,600.0	(18,173.1)

Өмнөх оны үзүүлэлтээс орлого буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн хэмжээ, ОНХС-ийн санхүүжилт буурсан зэрэг нь гол нөлөө үзүүлжээ.

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 108140.6 мянган төгрөгөөр буюу 24.7 хувиар өссөн байна.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	437,240.3	545,380.9	108,140.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435,860.9	527,674.5	91,813.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,726.2	241,925.4	37,199.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,830.8	30,075.9	4,245.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,573.1	28,435.4	16,862.3

2104	Хангамж, бараа материалын зардал	24,793.7	32,058.8	7,265.1
2105	Нормативт зардал	402.0	71.1	(330.9)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,342.7	709.9	(7,632.8)
2107	Томилолт, зочны зардал	10,259.4	3,877.6	(6,381.8)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,057.4	19,166.3	(37,891.1)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,875.5	171,354.1	78,478.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,379.4	17,706.4	16,327.0

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад материаллаг өөрчлөлтөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 41444.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 16862.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 78478.5 мянга, урсгал шилжүүлгийн зардал 16327.0 мянган төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Дээрх зардлууд өссөн шалтгаан нь

- Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн,
- Төвлөрсөн халаалтын системд холбогдсоноос хамаарч халаалтын зардал,
- Нэг албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарснаар урсгал шилжүүлгийн зардал өмнөх оны үзүүлэлтээс өссөн.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 367427.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 367427.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2345.0 мянган төгрөгөөр бууруулж 365082.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 30593.5 мянган төгрөгөөр өсчээ. Тодруулбал: Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 41351.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5959.4 мянга, хангамж бараа материалын зардал 2178.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 99.5 мянга, урсгал шилжүүлгийн зардал 7450.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, эд хогшил урсгал засварын зардал 500.0 мянга, томилолт зочны зардал 5697.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 20247,8 мянган төгрөгөөр буурсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 365082.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 352877.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 11600.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 605.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 353477.6 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 11600.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагаанаас 1320.0 мянган төгрөгийн орлого, нийт 366397.6 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, 62.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 366334.7 мянган төгрөг буюу 100.3 хувьтай байгаа нь төсвийн санхүүжилтийг 537.3 мянган төгрөг илүү авч, өөрийн орлого 715.0 мянган төгрөгөөр илүү бүрдүүлж, зарцуулснаас шалтгаалжээ.

Хөт	Зор	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
70106	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	233,561.3	234,813.6	1,252.3
70106	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, ү	20,924.2	20,924.2	-
70106	80106	Баг, хорооны ҮАЗардал	79,069.4	79,069.4	-
70106	80205	Мэдээлэл, сурталчилгааны зарда	125.0	125.0	-
70106	80305	Биеийн тамирын уралдаан, тэмцэ	223.0	223.0	-
70106	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	7,450.0	7,450.0	-
70106	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	4,500.0	4,500.0	-
70106	82212	Хур хог хаягдал, орчны бохирдл	1,000.0	1,000.0	-
70106	82801	Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	-
71413	81701	Байгаль орчныг хамгаалах, нөхө	749.5	749.5	-
70801	82502	Мал эмнэлгийн үйлчилгээ	11,600.0	11,600.0	-
72208	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, ү	160.0	160.0	-
72208	80221	Гэрээт ажиллагсдын зардал	720.0	720.0	-
ДҮН			365,082.4	366,334.7	1,252.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 59069.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнд: Орон нутгийн төсвөөс 36152.1 мянга, бусад шатны төсвөөс 5462.4 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 6671.1 мянга, газрын дуудлага худалдааны дэнчингийн 10525.0 мянган төгрөгийн санхүүжилтийг холбогдох хууль, журмын хүрээнд бүрдүүлж, 259.0 мянган төгрөгийн орон нутгийн төсвийн орлогыг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан зөрчилд зөвлөмж өглөө.

Дээрх орлогын эх үүсвэрээс 38511.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу холбогдох арга хэмжээнд, 259.0 мянган төгрөгийн орлогыг зориулалт бусаар зарцуулж, 20298.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансаар сумын ОНХС-аас тавилга, тоног төхөөрөмжийн санхүүжилт 10000.0 мянган төгрөг, бусад санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 585.0 мянган төгрөг татан төвлөрүүлснийг авлагаар бүртгэсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой байдал хангалтгүй байна. тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 140 мэдээллийг хугацаанд нь оруулсан ч сар бүр 5 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Дарви сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан хэрэгжүүлжээ. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгдсэн тайланд тус байгууллагатай холбоотой 1 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж / санхүүгийн тайланг программаар гаргах/	1	-	1	-	-	-	100%
Нийт дүн	1	-	1	-			100%

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 51123.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 45873.2 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 5249.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардал, бусад орлого, зардлыг ангилал хооронд залруулан бүртгэсэн 15155.0
- Санхүүгийн байдлын тайланд 9719.3 мянган төгрөгийн авлага, 20298.9 мянган төгрөгийн өглөг залруулан бүртгэсэн
- Нэмэлт санхүүжилтийн тайланд 700.0 мянган төгрөгийн орлого, зардал залруулсан

Нийт 45873.2 мянган төгрөгийн бүртгэлийн алдаа, зөрчилд залруулга хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил байхгүй болно

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 5249.8 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

- Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

1.1. Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд

зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.

1.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль, журам зөрчигдөх, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу “Төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар зардлын эдийн засгийн ангилал баталсан шийдвэртэй тус тус нийцүүлэн төсвийг бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зохих зардлын эдийн засгийн ангиллаас зарцуулж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Төсвийн зарцуулалттай холбоотой

2.1. Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд үлдээж хуримтлуулаагүй.

2.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын журам зөрчигдөх, төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлтэй

2.3. Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3-д “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана” гэсэн заалттай нийцүүлж, сар бүрийн батлагдсан төсвийн 30-аас доошгүй хувийн нөөцийг бүрдүүлж, зориулалтын арга хэмжээнд зарцуулах бэлэн байдлыг хангаж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Орлого бүрдүүлэлттэй холбоотой

3.1. Илрүүлэлт: Орон нутгийн төсвийн хүү торгуулийн 290.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлж, зарцуулсан.

3.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль, журам зөрчигдөх

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн захирагч нь төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана”, 23 дугаар зүйлийн 23.9.3-д “Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого нь хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлогоос бүрдэнэ” гэсэн заалттай нийцүүлж, орон нутгийн төсвийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлж, зарцуулахгүй байх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Төсвийн зарцуулалттай холбоотой

4.1. Илрүүлэлт: Батлагдсан төсвийн зарлагаас 1252.3 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна.

4.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль, журам зөрчигдөх

4.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн хухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн захирагч нь төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана”, 41.2.2-д

“Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалттай нийцүүлэн, төсвийг бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	<i>Дарви сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ХОА-2021/75/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дарви сумын Засаг даргын Тамгын газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Батлагдсан төсвийн зарлагаас 1252.3 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан	1252.3	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Л.Мөнхжаргал Б.Баяр-Угтах
2	Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.	2357.5	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Л.Мөнхжаргал Б.Баяр-Угтах
3	Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд үлдээж хуримтлуулаагүй.	1350.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Л.Мөнхжаргал Б.Баяр-Угтах
4	Орон нутгийн төсвийн хүү торгуулийн 290.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан.	290.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Л.Мөнхжаргал Б.Баяр-Угтах
5	•Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардал, бусад орлого, зардлыг ангилал хооронд залруулан бүртгэсэн 15155.0 •Санхүүгийн байдлын тайланд 9719.3 мянган төгрөгийн авлага, 20298.9 мянган төгрөгийн өглөг залруулан бүртгэсэн	45873.2	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Л.Мөнхжаргал Б.Баяр-Угтах

	•Нэмэлт санхүүжилтийн тайланд 700.0 мянган төгрөгийн орлого, зардал залруулсан				
	ДҮН	51123.0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР